



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 5/10

Чингис хот

**Ч.Баярцолмонд сахилгын шийтгэл
ногдуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.4, 26 дугаар зүйлийн 26.1, 26.1.1, 26.3 дахь заалт, Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам"-ын 3, 4, 5-ын "а", 6, "Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журам"-ын 9.1, 10.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Ч.Баярцолмон нь 2017 оны 02 сарын 24-ний өдрийн 12 дэд хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээний оролцогч нарыг арга хэмжээ дуусах хүртэлх хугацаанд бүрэн хамруулаагүй тул сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ч.Баярцолмонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР